



ГАДААД ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, E-mail: info@mfa.gov.mn,
<http://www.mfa.gov.mn>

2019. 01. 10 № 09/144
танай _____-ны № _____-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

“Дипломат, албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар хооронд хэлэлцээр”-ийг Нью-Йорк хотноо 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр байгуулсан.

Уг хэлэлцээр түүний 10 дугаар зүйлд “Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулсан ба Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно” гэж заасны дагуу уг хэлэлцээр 2019 оны 2 дугаар сарын 7-ны өдрөөс хүчин төгөлдөр болохыг үүгээр мэдэгдэв.

Холбогдох байгууллагадаа уламжилна уу.

Хавсралт: Хэлэлцээрийн хуулбар

ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ,
ЭРХ ЗҮЙН ГАЗРЫН
ДЭД ЗАХИРАЛ



С.ГАНХУЯГ

Handwritten signature and notes in the bottom left corner.

Handwritten signature and notes in the bottom right corner, including a date stamp 080020.



**ДИПЛОМАТ, АЛБАН/СЕРВИС ПАСПОРТ
ЭЗЭМШИГЧДИЙГ ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН
БҮГД НАЙРАМДАХ АЗЕРБАЙЖАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Азербайжан Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх,

Хоёр улсын хооронд найрсаг харилцааг цаашид улам хөгжүүлэх эрмэлзэж,

Хүчинтэй дипломат, албан/сервис паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх замаар Хэлэлцэн тохиролцогч талуудын албаны хүмүүсийн зорчих явдлыг хөхиүлэн дэмжиж, хөнгөвчлөхийг эрмэлзэж,

Дараахь зүйлийг тохиролцов:

1 дүгээр зүйл

Хүчин төгөлдөр дипломат, албан/сервис паспорт эзэмшигч Хэлэлцэн тохиролцогч талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт анх нэвтэрсэн, гарсан эсхүл дамжин өнгөрсөн өдрөөс зуун наян (180) хоногийн дотор ер (90) хүртэл хоногоор Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэх, зорчиход визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

Энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын иргэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт зуун наян (180) хоногийн дотор ер (90)-ээс дээш хоног зорчих тохиолдолд урьдчилан виз авах үүрэгтэй.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт байрлах Дипломат төлөөлөгчийн газар, Консулын төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчийн газарт томилогдсон Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын хүчин төгөлдөр дипломат болон албан/сервис паспорт эзэмшигч иргэд, тэдгээрийн хүчин төгөлдөр дипломат болон албан/сервис паспорт эзэмшигч гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө зөвшөөрлийн (аккредитаци) виз авах үүрэгтэй.

3 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийн зорилгоор "хүчин төгөлдөр паспорт" гэдэгт Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын нутаг дэвсгэрээс гарах үед доод тал нь ер (90) хоногийн хүчинтэй хугацаатай паспортыг ойлгоно.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль ч талын дипломат, албан/сервис паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын нутаг дэвсгэрт зорчих үедээ тухайн Хэлэлцэн тохиролцогч талын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

5 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь тааламжгүй гэж үзсэн Хэлэлцэн тохиролцогч нөгөө талын иргэдийг нутаг дэвсгэртээ нэвтрүүлэхээс татгалзах, эсхүл зорчих хугацааг богиносгох, эсхүл цуцлах Хэлэлцэн тохиролцогч аль нэг талын эрх бүхий байгууллагын бүрэн эрхийг хөндөхгүй.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч талууд үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам болон олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн түр зогсоох эрхтэй.

Хэлэлцэн тохиролцогч талууд хэлэлцээрийн үйлчлэлийг түр зогсоох, эсхүл эргүүлэн цуцлах тухайгаа нэн даруй буюу 48 цагийн дотор дипломат шугамаар харилцан мэдэгдэнэ. Энэ шийдвэр нь мэдэгдэл хүлээн авсан өдрөөс хорин дөрвөн (24) цагийн дараа хүчин төгөлдөр болно.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч талууд энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болохоос 30 хоногийн өмнө дипломат, албан/сервис паспортын загварыг дипломат шугамаар харилцан солилцоно.

Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал шинэ дипломат болон албан/сервис паспорт нэвтрүүлэх, эсхүл өөрийн ашиглаж буй дипломат болон албан/сервис паспортод өөрчлөлт оруулах тохиолдолд тэрхүү шинэ, эсхүл өөрчлөлт оруулсан дипломат болон албан/сервис паспортын загварыг тэдгээрийг ашиглах зааварчилгааны талаарх мэдээллийн хамт шинэ паспорт нэвтрүүлэх, эсхүл паспортод өөрчлөлт оруулахаас доод тал нь гуч (30) хоногийн өмнө эдгээр паспортын загварыг дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа хүргүүлнэ.

8 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, эсхүл хэрэгжүүлэхэд үүссэн аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч талууд дипломат шугамаар шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл

Энэхүү хэлэлцээрт Хэлэлцэн тохиролцогч талууд харилцан зөвшилцөх замаар аливаа нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийнхүү оруулсан нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн салшгүй хэсэг болох бие даасан протоколын хэлбэртэй байх бөгөөд энэхүү хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулсан ба Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Хэлэлцэн тохиролцогч аль нэг тал дипломат шугамаар хэлэлцэн тохиролцогч нөгөө талдаа бичгэн мэдэгдэл хүргүүлэх замаар энэхүү хэлэлцээрийг хэдийд ч цуцалж болно. Энэхүү хэлэлцээр уг мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ер (90) хоногийн дараа хүчингүй болно.


Нью Йорк хотноо 2018 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр монгол, азербайжан, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД
ДАМДИНЫ ЦОГТБААТАР

БҮГД НАЙРАМДАХ АЗЕРБАЙЖАН
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ



ГАДААД ХЭРГИЙН САЙД
ЭЛЬМАР МАМЕДЪЯРОВ



**AGREEMENT BETWEEN
THE GOVERNMENT OF MONGOLIA
AND
THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF AZERBAIJAN
ON THE EXEMPTION OF VISA REQUIREMENTS
FOR HOLDERS OF DIPLOMATIC, SERVICE AND OFFICIAL PASSPORTS**

The Government of Mongolia and the Government of the Republic of Azerbaijan, hereinafter referred to as the "Contracting Parties",

Being guided by the desire to develop further friendly relations between the two States,

Desiring to promote, facilitate and encourage exchange of visits of officials of the Contracting Parties by the exemption of visa requirements for holders of their valid diplomatic, service and official passports,

Have agreed as follows:

Article 1

Nationals of either Contracting Party holding valid diplomatic, service and official passports shall be exempted from visa requirements for entry into, stay not exceeding

ninety (90) days within one hundred eighty (180) days from the date of their first entry, exit from or transit through the territory of the other Contracting Party.

Nationals of either Contracting Party referred to in paragraph 1 of this Article, who wish to stay more than ninety (90) days within one hundred eighty (180) days in the territory of the other Contracting Party, shall be required to obtain a visa in advance.

Article 2

Nationals of either Contracting Party holding valid diplomatic, service and official passports who are appointed to diplomatic missions, consular posts or are representatives in the international organizations located in the territory of the other Contracting Party, as well as their family members holding valid diplomatic, service and official passports, shall be required to obtain a visa for accreditation by the receiving State prior to their arrival.

Article 3

For the purposes of this Agreement, "valid passport" shall mean the passport that, at the time of the exit from the territory of one of the Contracting Parties, has at least ninety (90) days validity.

Article 4

Nationals of either Contracting Party, holding valid diplomatic, service and official passports, shall abide by the laws and regulations of the other Contracting Party during their stay in that Contracting Party.

Article 5

This Agreement shall not restrict the right of the competent authorities of either Contracting Parties to deny the entry into or shorten or terminate the stay in the state territories to those nationals of the State of the other Contracting Party whom it may consider undesirable.

Article 6

The Contracting Parties shall have the right to temporarily suspend the implementation of this Agreement totally or partly, for reasons related to national security, public order or public health.

The Contracting Parties shall immediately, but not later than 48 hours notify each other through diplomatic channels about the decision on adoption and termination of such suspension. The decision shall become effective twenty-four (24) hours after the date of receipt of such notification.

Article 7

The Contracting Parties shall exchange through diplomatic channels specimens of their diplomatic, service and official passports not later than thirty (30) days before the entry into force of this Agreement.

In case of introduction of new diplomatic, service and official passports or modification of such existing passports, the Contracting Parties shall convey to each other, through diplomatic channels, specimens of these passports, accompanied by detailed information on their applicability at least thirty (30) days prior to their introduction or modification.

Article 8

Any disagreements that might arise out of the interpretation or implementation of this Agreement shall be settled through diplomatic channels between the Contracting Parties.

Article 9

Any additions and amendments may be made to this Agreement by mutual consent of the Contracting Parties. Such additions and amendments shall be made in the form of separate Protocols being an integral part of this Agreement and shall enter into force in accordance with the provisions of Article 10 of this Agreement.

Article 10

This Agreement is concluded for an indefinite period of time and shall enter into force thirty (30) days after the date of the receipt of the last written notification, through diplomatic channels, that the requirements envisaged by the national legislation of both Contracting Parties for its entry into force have been met.

Either Contracting Parties may terminate this Agreement at any time by informing the other Contracting Party in written through diplomatic channels. The validity of this Agreement shall cease ninety (90) days from the date on which such notice has been received.


Done at New York, on ~~27~~ of September 2018, in two original copies, each in the Mongolian, Azerbaijani and English languages, all text being equally authentic. In case of divergence regarding interpretation, the English text shall prevail.

FOR THE GOVERNMENT OF
MONGOLIA



.....
DAMDIN TSOGTBAATAR
MINISTER FOR FOREIGN AFFAIRS

FOR THE GOVERNMENT OF
THE REPUBLIC OF AZERBAIJAN



.....
ELMAR MAMMADYAROV
MINISTER OF FOREIGN AFFAIRS



**MONQOLUSTAN HÖKUMƏTİ İLƏ AZƏRBAYCAN RESPUBLİKASI HÖKUMƏTİ
ARASINDA
DİPLOMATİK, XİDMƏTİ VƏ RƏSMİ PASPORTLARA MALİK OLAN ŞƏXSLƏRİN
VİZA TƏLƏBİNDƏN AZAD EDİLMƏSİ HAQQINDA
SAZİŞ**

Bundan sonra "Razılığa gələn Tərəflər" adlandırılacaq Monqolustan Hökuməti və Azərbaycan Respublikası Hökuməti;

iki dövlət arasındakı dostluq münasibətlərini gələcəkdə də inkişaf etdirmək niyyətini rəhbər tutaraq,

etibarlı diplomatik, xidməti və rəsmi pasportlarına malik olan şəxslərin viza tələbindən azad edilməsi ilə Razılığa gələn Tərəflərin rəsmilərinin səfər mübadiləsini təşviq etmək, yardım göstərmək və həvəsləndirmək niyyəti ilə,

aşağıdakılar barədə razılığa gəldilər:

Maddə 1

Razılığa gələn Tərəflərdən birinin etibarlı diplomatik, xidməti və rəsmi pasportlarına malik olan vətəndaşları digər Razılığa gələn Tərəfin ərazisinə daxil olmaq, ilk dəfə daxil olduqları tarixdən etibarən yüz səksən (180) gün ərzində doxsan

(90) gündən artıq olmayan müddətdə orada qalmaq, oranı tərk etmək və oradan tranzit keçmək üçün viza tələbindən azad edirlər.

Razılığa gələn Tərəflərdən birinin digər Razılığa gələn Tərəfin ərazisində yüz səksən (180) gün ərzində doxsan (90) gündən artıq qalmaq istəyən bu maddənin 1-ci bəndində adıçəkilən vətəndaşlarından əvvəlcədən viza əldə etmək tələb olunur.

Maddə 2

Razılığa gələn Tərəflərdən hər birinin digər Razılığa gələn Tərəfin ərazisində yerləşən diplomatik nümayəndəliyə, konsulluğa təyin olunan və ya beynəlxalq təşkilatlarda nümayəndə olan etibarlı diplomatik, xidməti və rəsmi pasportlara malik vətəndaşlarından, eləcə də onların etibarlı diplomatik, xidməti və rəsmi pasportlara malik olan ailə üzvlərindən ölkəyə daxil olmazdan əvvəl Qəbul edən Dövlətdə akkreditasiya üçün viza əldə etmək tələb olunur.

Maddə 3

Bu Sazişin məqsədləri üçün, "etibarlı pasport" dedikdə Razılığa gələn Tərəflərdən hər hansı birinin ərazisini tərk edərkən ən azı doxsan (90) gün etibarlılıq müddəti olan pasport nəzərdə tutulur.

Maddə 4

Razılığa gələn Tərəflərdən hər birinin etibarlı diplomatik, xidməti və rəsmi pasportlara malik olan vətəndaşları digər Razılığa gələn Tərəfin ərazisində olduğu müddətdə həmin digər Razılığa gələn Tərəfin qanun və qaydalarına riayət edirlər.

Maddə 5

Bu Saziş Razılığa gələn Tərəflərdən hər birinin səlahiyyətli qurumlarının digər Razılığa gələn Tərəfin dövlətinin arzuolunmaz hesab etdiyi vətəndaşlarının öz dövlətinin ərazisinə daxil olmasından imtina etmək, orada qalma müddətini qısaltmaq və ya ləğv etmək hüququnu məhdudlaşdırmır.

Maddə 6

Razılığa gələn Tərəflər milli təhlükəsizlik, ictimai asayiş və ya əhalinin sağlamlığının qorunması məqsədilə bu Sazişin tətbiqini müvəqqəti olaraq tam və ya qismən dayandırmaq hüququna malikdirlər.

Razılığa gələn Tərəflər bir-birini dərhal, lakin 48 saatdan gec olmayaraq belə dayandırmanın qəbulu və ləğvi ilə bağlı qərar barədə diplomatik kanallar vasitəsilə

məlumatlandırılır. Qərar belə bildirişin alınmasından iyirmi dörd (24) saat sonra qüvvəyə minir.

Maddə 7

Razılığa gələn Tərəflər bu Sazişin qüvvəyə minməsindən ən azı otuz (30) gün əvvəl diplomatik kanallar vasitəsilə özlərinin diplomatik, xidməti və rəsmi pasportlarının nümunələrini mübadilə edirlər.

Yeni diplomatik, xidməti və rəsmi pasportlar dövriyyəyə buraxıldıqda və ya mövcud pasportlara dəyişikliklər edildikdə, bu nümunələrin dövriyyəyə buraxılmasından və ya dəyişikliklərin edilməsindən ən azı otuz (30) gün əvvəl, Razılığa gələn Tərəflər bir-birinə diplomatik kanallar vasitəsilə onların tətbiqi barədə təfəssilatlı məlumatla müşayiət olunmaqla bu pasportların nümunələrini göndərirlər.

Maddə 8

Bu Sazişin təfsiri və ya həyata keçirilməsi ilə bağlı yarana biləcək hər hansı fikir ayrılıqları Razılığa gələn Tərəflər arasında diplomatik kanallar vasitəsilə həll edilir.

Maddə 9

Tərəflərin qarşılıqlı razılığı ilə bu Sazişə əlavə və dəyişikliklər edilə bilər. Belə əlavə və dəyişikliklər bu Sazişin ayrılmaz tərkib hissəsi olan ayrıca protokollar formasında rəsmiləşdirilir və bu Sazişin 10-cu maddəsinin müddəalarına uyğun olaraq qüvvəyə minir.

Maddə 10

Bu Saziş qeyri-müəyyən müddətə bağlanılır və onun qüvvəyə minməsi üçün hər iki Razılığa gələn Tərəfin milli qanunvericiliyində nəzərdə tutulan tələblərin yerinə yetirilməsi barədə sonuncu yazılı bildirişin diplomatik kanallar vasitəsilə alındığı tarixdən otuz (30) gün sonra qüvvəyə minir.

Hər bir Razılığa gələn Tərəf digər Razılığa gələn Tərəfi diplomatik kanallar vasitəsilə yazılı şəkildə məlumatlandırmaqla bu Sazişi istənilən vaxt ləğv edə bilər. Bu Sazişin qüvvəsi belə bildirişin alındığı tarixdən doxsan (90) gün sonra başa çatır.


Nyu-York şəhərində, 2018-ci il "27" sentyabr tarixində, hər biri monqol, Azərbaycan və ingilis dillərində olmaqla iki əsl nüsxədə imzalanmışdır, bütün mətnlər bərabər autentikdir. Təfsir zamanı fikir ayrılığı yarandığı təqdirdə ingilis dilindəki mətnə üstünlük verilir.

**MONQOLUSTAN
HÖKUMƏTİ ADINDAN**



**DAMDİN TSOGTBAATAR
MONQOLUSTANIN
XARİCİ İŞLƏR NAZİRİ**

**HÖKUMƏTİ ADINDAN
AZƏRBAYCAN RESPUBLİKASI**



**ELMAR MƏMMƏDYAROV
AZƏRBAYCAN
RESPUBLİKASININ XARİCİ
İŞLƏR NAZİRİ**